

# ДОТООДЫН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО  
ХОНОГИЙН ТОЙМ**



2025.09.22

## Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

## ТОВЧ

- СЗХ Говь ХК-нд шаардлага хүргүүлээ
- Монголбанк бодлогын хүүг 12%-д хэвээр нь хадгаллаа
- MSE:QPAY хувьцаа хулдалдаж авахад тохиромжтой ханш дээрээ байна
- ERDN хувьцаа идэвхтэй арилжаалагдаж эхэллээ

## МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	-0.05%	-0.71%	25.47%
MSE A	0%	-1.21%	20.27%
MSE B	0.32%	-0.21%	34.89%

2025/09/15 – 2025/09/19

## Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
ERDN	1,262,799,420.00
KHAN	1,241,074,232.00
INV	834,498,580.00
CUMN	528,776,056.41
MGLA	504,803,611.00

2025/09/15 – 2025/09/19

## Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
HSG	15,800.00	32.11%
MCH	627.00	30.63%
MNP	699.00	16.75%
MBG	15.00	15.38%
EAZ	345.00	15.00%

2025/09/15 – 2025/09/19

2025 он 09-р сарын 22

Зах зээлийн  
үнэлгээ тэрбум ₮

12,868

ТОП-20 индекс

48,960

MSE A

18,866

MSE B

14,598



## МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

5.6%

2025 - II улирал

Инфляц

8.1%

2025-07 сар

ГВУН(сая\$)

5,683.43

2025-08 сар

Бодлогын

хүү

12.0%

ЗГ-ын бондын  
өгөөж

6.6%

USD/MNT

3,594.52

2025-09-21



## Эдийн засгийн мэдээлэл

### ГОВЬ ХК –ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй “Говь” ХК 2025 оны 9-р сарын 8-нд болсон хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар компанийн хэлбэрээ хязгаарлагдмал хариуцлагатай компани болгохоор шийдвэрлэжээ.

Үүний дагуу компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцааг эргүүлэн худалдан авах, үнийг тогтоох болон хувьцаа эзэмшигчдийн шаардах эрхийг хэрэгжүүлэх журмыг баталж, шаардлагатай баримт бичгийг МХБ-д хүргүүлсэн байна.

МХБ нь уг өөрчлөлттэй холбоотой хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн шийдвэр, компанийн өөрчлөх төсөл, аудит ба хөрөнгийн үнэлгээний тайлан, хувьцааг эргүүлэн худалдан авах үнэ зэрэг асуудлыг хянан шалгаж байгаа бөгөөд жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хамгаалагдаж буй эсэхийг онцгойлон харгалзаж байна.

Хуульд зааснаар Санхүүгийн зохицуулах хороо зөвшөөрөл олж, компанийн хувьцааг бүртгэлээс хасах шийдвэр гаргасны дараа “Говь” ХК-ийн хэлбэрийг өөрчлөх нөхцөл бүрдэх юм. Түүнээс өмнө тус компанийн хувьцаа МХБ дээр хэвийн арилжаалагдсаар байх болно.

### МОНГОЛ БАНК БОДЛОГЫН ХҮҮГ 12%-Д ХЭВЭЭР НЬ ХАДГАЛЛАА

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2025 оны 9-р сарын 15, 16-ны өдрүүдэд ээлжит хурлаа хийж, эдийн засаг, банк санхүүгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал болон дотоод, гадаад орчны төлөв, эрсдэлийг харгалзан бодлогын хүүг 12 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргалаа.

Жилийн инфляц 8-р сард улсын хэмжээнд 8.8 хувь, Улаанбаатарт 9.8 хувьтай гарсан байна. Энэ оны 2-р сараас хойш хатуу мөнгөний бодлогын нөлөөгөөр инфляц алгуур буурсан ч мах, хүнсний ногоо, гурилын үнэ нэмэгдсэнээр хүнсний инфляц өсжээ. Ирэх 2-3 сард хүнсний үнэ дахин өсөх эрсдэл байгаа ч урт хугацаандаа инфляц буурч, 2026 онд зорилтот түвшинд хүрнэ гэсэн хүлээлт хэвээр байна. Гэхдээ Засгийн газрын хэрэгжүүлэх төслүүдийн санхүүжилт, экспортын орлого, валютын ханшийн хэлбэлзэл, цаг агаар болон нийлүүлэлтийн өөрчлөлтүүд инфляцад дарамт үзүүлэх эрсдэлтэй.

Эдийн засаг 2025 оны эхний хагаст 5.6%-ийн өсөлт үзүүлсэн бөгөөд үүнд хөдөө аж ахуйн салбарын өсөлт голлох нөлөө үзүүлжээ. Оны сүүлийн хагаст зэсийн баяжмалын олборлолт нэмэгдэх болон шинэ төслүүдийн бүтээн байгуулалт эхлэх нь эдийн засгийг дэмжих хүлээлттэй байна.

Гадаад орчинд, АНУ-ын тарифын түвшин анхны зарласнаас бага тогтож, дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл бага зэрэг дээшилсэн ч тодорхойгүй байдал өндөр хэвээр байгаа нь анхаарал татаж байна. Монголбанкны энэ удаагийн шийдвэр нь инфляцыг дунд хугацаанд тогтворжуулах, эдийн засаг болон санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад чиглэж байгаа юм. Цаашид дотоод, гадаад эдийн засгийн нөхцөл болон инфляц, өсөлтийн төлөвөөс шалтгаалан бодлогын дараагийн алхмуудыг тухай бүрт нь авч хэрэгжүүлэхийг Мөнгөний бодлогын хороо мэдэгдлээ.

## Зах зээлийн мэдээлэл

### ТОП-20 ИНДЕКС ОН ГАРСНААС ХОЙШ 6.23% УНАЛАА


График 2. ТОП-20 индексийн ханшийн өөрчлөлт



ТОП-20 индекс 2025 он гарснаар 6.23 хувиар унаад байна. Компаниудын орлого эхний хагас жилд өссөн ч гэсэн цэвэр ашиг өнгөрсөн оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байлаа. Ханш 46,300 түвшин рүү үргэлжлэн унах магадлал өндөр бөгөөд 46,300 хүчтэй дэмжлэгийн бүс болж байна. Энэ оны сүүлийн улиралд индекс хүчтэй өсөх магадлалай.

### QPAУ ХУВЬЦАА ХУДАЛДАЖ АВАХАД ТОХИРОМЖТОЙ ТҮВШИН ДЭЭРЭЭ БАЙНА

График 3. P/E болон P/B харьцаа



QPAУ-н 3 жилийн цэвэр ашиг нь өнөөдрийн зах зээлийн үнэлгээтэй тэнцүү байгаа нь цаашдаа хувьцааны ханш нь өсөх боломжтойг илэрхийлж байна. Мөн дундаж P/E харьцаанаас 2 дахин бага байна.

2024 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд нийт 40₮ ногдол ашиг тараав. Энэ жил нийт цэвэр 14 тэрбумд хүрнэ гэж таамаглаж, ашгийн 74%-г ногдол ашиг хэлбэрээр тараана гэж үзвэл +10₮ тэрбумыг тараах магадлалтай.


Өөрийн хөрөнгийн хэмжээ 22.7₮ тэрбум байгаа нь ногдол ашгийг өндөр тараах магадлал өндөртэйг илэрхийлж байна. Мөн нийт хөрөнгийн ихэнх хувийг өөрийн хөрөнгө эзэлж байна. Гүйлгээний тоо нэмэгдэж байгаа нь борлуулалтын орлого тогтмол өсөлттэй байх үндэс юм. QPAУ-н хувьцааны ханшийн гүйцэтгэл ТОП-20 индексийн өсөлтийн гүйцэтгэлийг нөхөх боломжтой.

## ДОТООДЫН ХУВЬЦААНД ХЭЗЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

ТОП-20 индексийн хэлбэлзэл (2015-2025)

	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	ДУНДАЖ
1 сар	-2.10%	-1.00%	5.40%	-4.20%	7.50%	0.90%	10.50%	1.90%	3.50%	7.00%	2.90%	2.90%
2 сар	-3.50%	-3.00%	-0.90%	-0.10%	-0.60%	-0.90%	29.20%	-4.60%	2.40%	5.50%	1.70%	2.30%
3 сар	-3.50%	-5.10%	4.60%	-1.00%	-2.60%	-4.00%	31.20%	-6.10%	0.50%	1.90%		1.60%
4 сар	-3.00%	-1.50%	2.50%	-4.60%	-3.70%	-8.70%	4.10%	-0.90%	-5.20%	-3.30%		-2.40%
5 сар	-2.40%	-1.20%	-1.60%	-2.00%	0.30%	-2.10%	1.20%	-6.70%	0.50%	-0.40%		-1.40%
6 сар	13.90%	5.20%	-1.60%	0.90%	-1.80%	-1.00%	-7.70%	-3.70%	-0.60%	0.80%		0.50%
7 сар	-2.60%	10.80%	8.20%	-1.00%	3.60%	2.00%	-1.10%	-0.80%	1.10%	9.80%		3.00%
8 сар	-6.70%	-1.80%	8.70%	-0.90%	-2.80%	1.60%	7.70%	4.60%	0.00%	3.50%		1.40%
9 сар	-0.40%	-7.40%	16.60%	3.50%	-3.20%	2.70%	27.50%	-1.50%	-5.40%	-1.30%		3.10%
10 сар	-0.60%	-2.70%	16.90%	2.10%	-3.60%	1.60%	-10.00%	-1.90%	0.60%	0.20%		0.30%
11 сар	-2.90%	-3.40%	9.30%	-2.00%	0.00%	0.50%	-2.40%	1.10%	4.60%	1.80%		0.70%
12 сар	-3.60%	7.00%	0.10%	0.10%	1.90%	3.30%	5.80%	5.40%	5.00%	2.00%		2.70%

ТОП-20 индексийн сарын дундаж хэлбэлзэл (2015-2025)



Монголын ТОП-20 индексийн дундаж хэлбэлзлээс харахад 1-3 сар, 7-9 сар, 12 саруудад өсөлт давамгайлдаг байна.

### Ямар стратеги баримтлах вэ?

- Ногдол ашиг хүртэхийг зорьж буй бол 1-3 сард хувьцаа худалдаж авах нь тохиромжтой.
- Хямд үнээр хувьцаа авах боломж хайж байгаа бол 4-5 сард зах зээлийн уналтыг ашиглах хэрэгтэй.
- 7-9 сард зах зээл өсөх магадлалтай тул эрт худалдан авч, өсөлтийг ашиглах боломжтой.
- Жилийн эцэст (12-р сар) дунд хугацааны өсөлт ажиглагдах хандлагатай тул урт хугацааны хөрөнгө оруулалтад тохиромжтой үе.